

МОНГОЛ, ЯПОНЫ ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ ХӨГЖЛИЙН ҮЕЧЛЭЛ

Н.Бадрал¹

Дипломат үйл ажиллагаа нь тухайн орны гадаад бодлогыг хэрэгжүүлэх гол хэрэглүүр, улс үндэстний эрх ашгийг хилийн чанадад хамгаалах зорилгыг агуулсан өргөн хүрээтэй ажиллагаа байдаг юм.

Монголын дипломатын түүхэн баримтуудаас харахад улс эх орныхоо эрх ашгийг хамгаалах, түүний төлөө зүтгэх ёс эрт дээр үеэс улбаатай ажээ. Энэ талаар проф. Н.Алтанцэцэг “Чингис хааны үнэлгээний талаарх гадаадын (орос, өрнөд, хятад) судлаачдын судалгаа, үзэл баримтлал” бүтээлдээ тусгасан үзэл санаа нь Монголын хаад төрийн гадаад харилцаа хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж ирснийг тодорхой харуулсан байдаг. /1.х.17/

Тодруулбал, 13-14 дүгээр зуунд монголчууд дипломат ажиллагааг амжилттай явуулж олон улсын хэмжээнд улс төр, нийгмийн харилцаа, худалдаа, эдийн засгийн сэтгэлгээгээр давамгайлж байсан энд үедХубилай хаан гадаад бодлогынхоо нэг чиглэлийг Япон улс руу хандуулж найрамдан дагаар орохыг шаардан 6 удаа элч илгээснийг үл тоомсорлосны хариу хоёр удаагийн далайн дайн явуулж байсан нь хоёр улсын өнө эртний харилцаатай байсныг харуулж байна.

Проф. Ж.Баясах “Нүүдлийн хийгээд суурин соёл иргэншлийн ялгаа, харилцан хамаарлын асуудалд” бүтээлдээ “Япон улс монголчуудтай анхлан Хубилай хааны үед, дараа нь XX зууны эхнээс дахин түүхийн эрхээр холбогдсон бөгөөд...улмаар 1972 онд манай хоёр улс хоорондоо дипломат харилцаа тогтоосон” гэж хоёр улсын түүхэн харилцааг онцолсон байдаг.

Эдүгээ Монгол улс ардчилал, зэх зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн 1991 оноос хойш Монгол, Япон хоёр улс эрх чөлөө, ардчиллын нийтлэг үнэт зүйлст тулгуурласан найрамдалт харилцаа хөгжүүлж ирсэн бөгөөд 1997 онд харилцааг “иж бүрэн түншлэл”-ийн зарчмаар хөгжүүлэх тухай гадаад бодлогын нэгдмэл зорилтыг тунхаглан бүх салбарт харилцаа амжилттай хөгжиж ирлээ. Иж бүрэн түншлэлийн харилцааг хөгжүүлж ирсэн хамтын хүчин чармайлт тодорхой үр дүнд хүрч, харилцааны шинэ бөгөөд түүний дээд шат болох “стратегийн түншлэл” байгуулахад чиглэсэн алхам хийж, Монгол улсын Ерөнхийлөгчийн Төрийн айлчлал амжилттай өндөрлөсөн юм.

Ийнхүү хоёр ард түмэн өнө эртнээс түүхийн тодорхой үеүдэд харилцаж өнөөдөр харилцааны хөгжлийн дээд шатанд хүрч чаджээ.

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

I. Монгол- Японы хооронд дипломат харилцаа тогтсон нь

Монголын тал Японоос дайны төлбөр нэхэж, Японы тал Монголтой дайн хийж байгаагүй, төлбөр төлөхгүй гэж арав гаруй жил мэтгэлцэн харилцан ойлголцолд хүрэхгүй байсаар 1972 оны 2 дугаар сарын 24-ны өдөр дипломат харилцаа тогтоосон юм /13.х.26/.

БНМАУ-ын Элчин сайд Н.Лувсанчүлтэм бээр атташе Р.Отгон, япон хэлний орчуулагч Д. Алмас нарыг дагалдуулан Токиод очиж 1972 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Японы эзэн хаан Хирохитод итгэмжлэх (ИЖБ) барьсан ажээ. Элчин сайд, Ерөнхий сайд Э.Сато, Гадаад хэргийн сайд Т.Фүкүда, Парламентын гишүүд болон албаны бусад хүмүүс Япон-Монголын эдийн засгийн хороо, Найрамдлын нийгэмлэгүүдийн удирдлагуудтай уулзаж хоёр орны харилцааны асуудлаар санал солилцож Японы талаас Монголын өмнө хүлээх “Дайны төлбөр” нь санаа сэтгэлийн үүрэг байх ёстой гэдгийг цохон тэмдэглэсэн байна. Үүний дагуу БНМАУ, Япон улсын хооронд эдийн засгийн хамтран ажиллах хэлэлцээр байгуулсан. Тухайлбал:

Японы засгийн газар Монголын засгийн газарт 5 тэрбум хүртэлх иенийн грант өгнө.

Уг мөнгийг ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр барихад шаардагдах материал, машин тоноглол зэргийг авахад зарцуулна гэж бичсэн байдаг.

- Японы компанитай гэрээ байгуулах ажлын үе шат эхэлж Марубэни, Иточү компанийн төлөөлөгчид 7 дугаар сард Улаанбаатарт ирж хэлэлцээ хийж эхэлсэн.
- БНМАУ-ын Хөнгөн хүнсний үйлдвэрийн яам 1982 оны 2 дугаар сард ноолуур боловсруулах туршилтын жижиг үйлдвэрийг “Товь” комбинатын харьяанд шилжүүлжээ.

Монгол улсын Засгийн газар Элчин сайдын газраа 1973 оны 12 дугаар сарын 24-ны өдөр Токио хотноо нээсэн бөгөөд энэ нь 1990-ээд он хүртэл өргөн бус боловч хэвийн үйл ажиллагаа явуулж иржээ.

II. Монгол, Японы дипломат харилцааны идэвхтэй хөгжлийн үе шат

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа 1991 онд Япон улсын Ерөнхий сайд Т.Кайфу манай оронд албан ёсны айлчлал хийснээр бүх салбарт идэвхжиж, өдгөө “иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд хүрсэн юм. Монгол, Японы Засгийн газар, Парламентын болон бусад түвшинд өндөр хэмжээний томоохон айлчлалууд хийсэн байна. 1998 оны 5 дугаар сард Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Япон улсад албан ёсны айлчлал хийхдээ гаргасан хоёр орны найрамдал, хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл нь иж бүрэн түншлэлийн харилцааг 21 дүгээр зуунд урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн улс төрийн баримт бичиг болсон.

Ийнхүү Монгол-Японы эдийн засгийн харилцаа 1980-аад оны сүүлчээс идэвхжиж эхэлснээс хойш 20 гаруй жил болж байна. Тухайлбал, Монгол улсад 1989 оны эхээр Монгол-Японы эдийн засгийн харилцааны комисс байгуулагдаж, мөн онд Япон улсын Монголтой харилцах эдийн засгийн хороотой хамтарсан хуралдаан болсон юм. Хэдийгээр 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэн үед манай хоёр улсын нийгэм-эдийн засгийн тогтолцоо нилээд ялгаатай байсан хэдий ч тухайн үед Монголын талаас тодорхой асуудлыг шургуухан тавьж байсны үр дүнд жилд 100,000 тонн ган хайлах хар төмөрлөгийн үйлдвэр байгуулах, Улаанбаатар-Замын Үүд хүртлэх төмөр замын хүчин чадавхийг нэмэгдүүлэх, Замын Үүдэд вагоны дугуй солих байгууламж барьж байгуулах, Улаанбаатарын IV цахилгаан станцын зарим хэсэгт технологийн шинэчлэлт хийх, сансарын холбооны газрын А стандартын станц байгуулах зэрэг нэлээд ажил хийсэн байна.

1990 онд худалдааны тухай хэлэлцээр, 1993 онд агаарын харилцааны тухай хэлэлцээр, 2001 онд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр, 2003 онд техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг тус тус байгуулсан. 2007 оны 2 сарын 26-нд Ерөнхий сайд Ш.Абэ Япон улсад Төрийн айлчлал хийж буй Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяртай хийсэн дээд хэмжээний уулзалтаар Япон, Монголын хамтарсан мэдэгдэл болон Япон, Монголын хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр зэргийг гарсан билээ.

Япон-Монголын харилцаа нь 1996 онд тохиролцсон “иж бүрэн түншлэл”-ийн зарчимд тулгуурлан ихээхэн хөгжиж ирсэн нь нааштай үзүүлэлт бөгөөд үүнийг шинэ шатанд гарган хөгжүүлэхийн тулд “Япон-Монголын хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр”-т тулгуурлан бодитой үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрэх нь чухал гэдэгт хоёр улсын тэргүүнүүд санал нэг байгаагаа илэрхийлсэн нь Монгол-Японы дипломат харилцааны хөгжлийн шинэ үе шат буюу стратегийн үе шат эхэлж буй хэмээн үзэх боломжтой юм. Монгол-Японы хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр батламжилснаас хойш Японы Засгийн газрын хөнгөлттэй зээл болон буцалтгүй тусламжаар Хөшигтийн хөндийн нисэх онгоцны буудал болон Улаанбаатарын Энгельсийн гудамжинд гүүрэн гарц барих төслийг хэрэгжүүлэх ажил үйлс эхлэж байгаа билээ (8).

III. Монгол, Японы дипломат харилцааны стратегийн үе шат:

“Стратегийн түншлэл” байгуулахад чиглэсэн Монгол, Японы хамтарсан мэдэгдэлд Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Япон улсын Ерөнхий сайд Н.Кан нар гарын үсэг зурж, хэлэлцээ хийлээ. Хэлэлцээний эхэнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон улсын Засгийн газрын урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийж буйдаа баяртай байгаагаа илэрхийлсэн. Энэ удаагийн айлчлал Монгол, Японы ард түмний харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлж, улмаар хоёр орны харилцааг цаашид стратегийн түншлэлд хүргэж хөгжүүлэхэд чухал хувь оруулна гэдэгт итгэлтэй байгаагаа мөн Ерөнхийлөгч илэрхийлсэн.

“Монгол улсад ардчиллыг бэхжүүлэх, нийгэм эдийн засгийн шинэ тогтолцоог бүрдүүлэхэд Японы Засгийн газар, ард түмний дэмжлэг онцгой чухал үүрэг гүйцэтгэснийг Монголын ард түмэн, төр засаг өндөр үнэлж талархаж байдаг” гээд “Монгол-Японы харилцааг шинэ шатанд гаргаж, стратегийн түншлэлд хүргэж хөгжүүлэх чиглэл баримталж байгааг” тэмдэглэсэн байна. Энэ үүднээс Монгол улс хоёр талын өндөр дээд хэмжээний айлчлалын давтамжийг хадгалах, улс төрийн яриа хэлэлцээг тогтмолжуулах, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхийн төлөө байгааг тэмдэглэж, хоёр орны гадаад хэргийн сайд нарын уулзалтыг жил бүр зохион байгуулах тухай Японы талын саналыг талархан хүлээн авсан байна.

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах асуудлаар хоёр улсын Засгийн газар, хувийн хэвшил, судлаачдын төлөөллөөс бүрдсэн хамтарсан судалгааны баг үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд хэлэлцээр амжилттай болно хэмээн найдаж байгаагаа илэрхийлсэн юм. Монгол улс байгалийн болон эрдэс баялгийн нөөцөө эдийн засгийн эргэлтэд оруулснаар өөрийн орны эрчимтэй хөгжлийг хангах, улмаар бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Хоёр тал эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүчний салбарт, ялангуяа нүүрс, ус, газрын ховор элемент, ураны чиглэлээр хамтран ажиллах боломж бий гэдгийг Ерөнхийлөгч яриандаа дурьдлаа. Эрдсийн түүхий эдийг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дотооддоо боловсруулах аж үйлдвэрлэлийн цогцолбор

байгуулах төсөл хөтөлбөр гаргасныг тэмдэглэж, энэ чиглэлээр Японы талтай хамтран ажиллах боломжтой гэдгийг илэрхийлсэн.

Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимжүүлж, иргэдийн харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх зорилгоор Монгол улсын Засгийн газар энэ оны 4 дүгээр сарын нэгнээс эхлэн Японы иргэд манай улсад визгүй зорчих шийдвэр гаргасныг онцлон тэмдэглэж, Монголын иргэд Япон улсад зорчих визийн нөхцлийг хөнгөвчлөх талаар арга хэмжээ авна гэдэгт найдаж байгаагаа илэрхийллээ.

Боловсрол, хүмүүнлэгийн салбар бол хамтын ажиллагаа харилцааны нэгэн чухал хэсэг байсаар ирсэн. Цаашид техник технологийн чиглэлээр суралцах оюутны тоог нэмэх хүсэлтэй байна гэж Ерөнхийлөгч яриандаа тэмдэглэсэн. Япон улсын Ерөнхий сайд Н.Кан Монгол улсын Ерөнхийлөгчийн энэхүү айлчлал түүхэн чухал ач холбогдолтой болж буйг хэлээд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн хүрсэн түвшинд сэтгэл хангалуун байдгаа илэрхийлэв. Тэрээр Япон улс Монгол улстай бүх салбарт хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх эрмэлзэлтэйг дахин нотлоод эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах үйл ажиллагаа амжилттай эхэлж байгааг сайшаасан байна./12/

Одоо хоёр улсын харилцаа иж бүрэн түншлэл тогтоохоор хөгжиж байна. Япон улс нь Монгол улсад ардчилал тогтсоноос хойш хамгийн том хандивлагч улс болсон бөгөөд харилцаа, хамтын ажиллагаа бүх салбарт идэвхтэй хөгжиж байна” хэмээн тэмдэглэсэн /7. х.41-42/. Ийнхүү хоёр орны харилцааг шинэ түвшинд гаргахын тулд “иж бүрэн түншлэл”-ийн зарчимд тулгуурлан өнөөг хүртэл хөгжүүлж ирсэн харилцаанд түшиглэн “Стратегийн түншлэл” байгуулах зорилт дэвшүүлэн ажиллахаар Япон улсын Ерөнхий сайд Н.Кан, Монгол улсын Ерөнхийлөгч нар санал нэг байгаагаа илэрхийлсэн байна. /12/ Стратегийн түншлэлийг байгуулахад дээд хэмжээний яриа хэлэлцээг идэвхжүүлэх нь чухал гэдэгтэй Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар санал мөн нэгдлээ. Эрдэс баялгийн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх нь хоёр орны эрх ашигт нийцнэ гэдгийг мөн харилцан илэрхийллээ. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар эдийн засаг, боловсрол, орон нутгийн болон бүс нутгийн хамтын ажиллагааны бусад асуудлаар ярилцсан болно.

Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Япон улсын Ерөнхий сайд Н.Кан нарын хэлэлцээ амжилттай болж, төгсгөлд нь хамтарсан мэдэгдэл гаргалаа. Хэлэлцээний дараа Монгол-Японы харилцаа, хамтын ажиллагааны баримт бичгүүдэд гарын үсэг зурах ёслол болов. Хоёр үе шатлалт иенийн зээлийн хоёр дахь үеийг хэрэгжүүлэх тухай Засгийн газар хооронд солилцох ноот бичигт Монголын талаас Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Японы талаас Гадаад харилцааны сайд С.Маэхара нар гарын үсэг зурлаа. Монгол, Японы хамтарсан мэдэгдэлд Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Япон улсын Ерөнхий сайд Н.Кан нар гарын үсэг зурсан. Ийнхүү стратегийн түншлэлийн шинэ алхам хийгдэж байна.

Эцэст нь дүгнэж үзвэл, Монгол-Японы дипломат харилцааг хөгжлийн гурван үе шат болгон авч үзэх боломжтой. Учир нь шат тус бүрт хоёр орны тухайн үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн байдал зэргээс хамааран өөр өөрийн онцлог бүхий хөгжлийн чиг хандлагатай байсан байна. Япон-Монгол орны харилцаа нь 1996 онд тохиролцсон “иж бүрэн түншлэл”-ийн зарчимд тулгуурлан ихээхэн хөгжиж ирсэн нь нааштай үзүүлэлт болно. Энэхүү хөгжлийн үечлэлийг шинэ шатанд гарган хөгжүүлэхийн тулд “Япон-Монголын хамтын ажиллагааны 10 жилийн

үндсэн хөтөлбөр”-т тулгуурлан, бодитой үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрэх нь чухал болсоор байна. Энэ бүхнээс үзэхэд Монгол-Японы дипломат харилцааны хөгжлийн шинэ үе шат буюу стратегийн үе шат эхэлж буй хэмээн үзэх боломжтой юм.

Ашигласан эх сурвалж:

1. Н.Алтанцэцэг. Чингис хааны үнэлгээний талаарх гадаадын /орос, өрнөд, хятад/судлаачдын судалгаа, үзэл баримтлал - “Олон улсын харилцаа”сэтгүүл. №1 273(12). УБ.,2006
2. モンゴル最新ニュース国際、外交 2010年10月
3. 世紀日本外交の基本戦略 — 新たな時代、新たなビジョン、新たな外交 — 2011年11月
4. 最近のモンゴル情勢と日・モンゴル関係 2011年12月
蒙日外交・系及日本的用心 2008年
5. Н.Бадрал. Олон улсын харилцааны толь бичиг/Монгол, япон, хятад / УБ., 2008
6. Ж.Баясах. “Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал” (Түүвэр зохиол) УБ., 2010
7. Ч.Далай нар. “Монгол, японы харилцаа: эрт, эдүгээ” Ред. Ц.Батбаяр, Ц.Төмөрхүлэг УБ.,2001
- 8.Т.Намжим .Монгол Японы түншийн харилцаа УБ 2010
- 9.Д.Цолмон. “Дипломат ёс горим төрийн ёслолын уламжлал, шинэчлэлийн зарим асуудал”-//”Олон улсын харилцаа”-сэтгүүл.№1 УБ.,2006.
10. ”Олон улсын харилцаа” сэтгүүл № 1 УБ., 2006
- 11.Тора Асо Эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум: Япон улсын өргөжин хөгжиж буй дипломат үйл ажиллагааны хүрээ-Олон улсын харилцаа// сэтгүүл.№1. УБ., 2006.х.136-144
- 12.Л.Хайсандай “Олон улс судлалын өгүүллүүд” УБ. 2003
- 13.Бусад эх сурвалж